

ЭРДЭНЭ РЕСУРС ХАР МОРИЙН ДЭЛ НЭЭЛТИЙН БҮСЭД ГАЗРЫН ДӨТ ГҮНД 33.5 Г/Т АЛТНЫ АГУУЛГА БҮХИЙ 8 МЕТРИЙН ИНТЕРВАЛ ОГТОЛОО

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2021.11.17

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь бүтээн байгуулалтын үе шат руу хөгжүүлж буй Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 2.4 км-т Хар Морийн Дэл бүсэд нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнг танилцуулахад таатай байна. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрөөр газрын дөт гүнээс алтны өндөр агуулга бүхий исэлдсэн хүдрийн бүсийг баталгаажуулсан нь судлын дагуу болон гүндээ нээлттэй.

Онцлох мэдээлэл

- Хар Морийн Дэл бүсийн өмнөд хэсэгт газрын дөт гүнд алтны өндөр агуулга бүхий исэлдсэн хүдрийн интервал огтлов:
 - ADD-146: Цооногийн 15 метрээс эхлэн 16.7 г/т алтны агуулга бүхий 17 метр
 - Үүнд 33.5 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал багтсан
 - ADD-137: Цооногийн 1.5 метрээс эхлэн 9.4 г/т алтны агуулга бүхий 24.5 метр
 - Үүнд 16.1 г/т алтны агуулга бүхий 13.5 метрийн интервал багтсан
 - ADD-138: Цооногийн 18 метрээс эхлэн 6.1 г/т алтны агуулга бүхий 25 метр
 - Үүнд 17.1 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал багтсан
 - ADD-136: Цооногийн 6 метрээс эхлэн 5.6 г/т алтны агуулга бүхий 30 метр
 - Үүнд 11.6 г/т алтны агуулга бүхий 13 метрийн интервал багтсан
- Өндөр агуулга бүхий исэлдсэн хүдрийг Баян Хөндийн боловсруулах үйлдвэрт боловсруулах боломжтой нь Баян Хөндий алтны төслийн цар хүрээ болон эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Хар Морийн Дэлийн хойд бүсэд хийсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр гүндээ хэтийн төлөв өндөртэй талбайг тодорхойлсон
 - AAD-92 цооногийн өргөтгөлөөр 100 метрийн өргөн хувирсан бүсэд хэд хэдэн алт агуулсан бүсийг илрүүлсэн нь 150 метрийн гүнд 1 г/т алтны агуулгаар төгссөн.
- Энэ долоо хоногоос Улаан талбайн өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлэх бөгөөд 2021 4-р улиралд Хар Морь талбайн нэмэлт өрөмдлөгийг эхлүүлнэ.
 - Ирээдүйн хайгуулын хөтөлбөрөөр судлын дагуу болон гүний судалгаа хийхээс гадна Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн талбайд бусад исэлдсэн хүдрийн бүсийг тогтоох зорилготой.

Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Энэхүү хөтөлбөрийн үр дүн нь Хөндий-Улаан хувирлын системийн цар хүрээг илэрхийлэхээс гадна Хар Морь төслийн Баян Хөндийн хөгжүүлэлт дэх үнэ цэнийг баталгаажууллаа. Газрын дөт гүн дэх өндөр агуулгатай исэлдсэн хүдэр бүхий алтны бүсүүд нь Баян Хөндий алтны төслийн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхээс гадна тусгай зөвшөөрлийн талбайд газрын дөт гүн дэх хэтийн төлөв бүхий бүсүүдийн ирээдүйн боломжуудыг тодорхойллоо. Хар Морь алтны бүс нь 1.5 км талбайг хамарч байгаа ба бүх зүгт тэлэх боломжтой.”

“Мөн Хар Морь, Баян Хөндий орд, Улаан нээлтийг багтаасан Хөндий-Улаан хувирлын тренд нь алт агуулсан гидротермаль системийн нэг хэсэг гэх бидний итгэлийг бэхжүүлсэн. Энэхүү систем нь хэдэн сая унц бүхий алтны ордыг агуулах боломжтой. Хар Морийн Дэлээс өмнө зүгт 3 км-ийн зайд Улаан талбайн хайгуулын хөтөлбөрийг эхлүүлж байгаа бөгөөд 4-р улиралд Хар Морь талбайд нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.”

Өрөмдлөгийн хөтөлбөрийн хураангуй

Энэхүү хэвлэлийн мэдээнд танилцуулсан өрөмдлөгийн үр дүнгүүд нь Хар Морийн Дэл бүсийн үр дүнгүүд юм. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрийн зорилго нь газрын дөт гүнд исэлдсэн хүдэр бүхий алтны эрдэсжилт үргэлжилж байгаа эсэх болон алтны агуулгыг баталгаажуулах явдал байв. Нийт 2,286 метрийн 32 цооног, 2 цооногийн өргөтгөл өрөмдсөн. Гурван цооногийг босоо тэнхлэгийн дагуу 109-318 метрийн гүнд өрөмдсөн бол дийлэнх (31) цооногийг 21-61 метрийн гүнд өрөмдөв.

Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр Хар Морийн Дэл бүс дэх 1.5 км-ийн хувирлын тренд, алтны эрдэсжилт нь өмнө хойд судлын дагуу нээлттэйг тогтоосон. Газрын дөт гүнд, исэлдсэн, суперген алтны эрдэсжилт нь өмнө зүгт 350 метр, хойд зүгт 500 метр сунаж буй нь тодорхойлогдсон.

Хүснэгт 1-д Хар Морийн Дэл (өмнөд)-ийн үр дүнгүүдийг харуулав. Үр дүнд супергенээр баяжуулсан, исэлдсэн хүдэр бүхий эрдэсжилт газрын дөт гүнээс эхэлж буйг баталсан. Хүснэгт 2-т Хар Морийн Дэл (хойд)-ийн үр дүнгүүдийг харуулсан. Хэдийгээр өмнөд Хар Морийн Дэл бүсээс бага агуулгатай боловч газрын дөт гүнд исэлдсэн хүдэр бүхий эрдэсжилт зонхилсон.

Хүснэгт 1: Хар Морийн Дэл (өмнөд) талбайн 2021 оны 4-р улирлын өрөмдлөгийн онцлох үр дүнгүүд (Дунджаар 0.30 г/т алтнаас өндөр агуулгатай интервалуудыг танилцуулав)

Цооног	м-ээс	м хүртэл	интервал ⁽¹⁾	г/т алт
AAD-134	164	165	1	0.58
AAD-135	14	24	10	0.31
AAD-136	6	36	30	5.59
Үүнд	10	23	13	11.63
Үүнд	16	20	4 ⁽²⁾	24.06

Цооног	м-ээс	м хүртэл	интервал ⁽¹⁾	г/т алт
AAD-137	1.5	26	24.5	9.37
Үүнд	4.5	18	13.5	16.08
Үүнд	4.5	9	4.5 ⁽²⁾	17.23
Үүнд	12	16	4 ⁽²⁾	27.68
AAD-138	18	43	25	6.06
Үүнд	26	34	8	17.07
Үүнд	25	26	1	29.94
Үүнд	31	34	3 ⁽²⁾	31.01
AAD-139	1.5	9	7.5	0.38
Ба	20	21	1	0.44
AAD-140	18	19	1	0.50
Ба	42	51	9	0.60
AAD-141	1.9	37	35.1	1.31
Ба	10	21	11	3.35
Үүнд	11	12	1	14.72
AAD-142	22	23	1	0.44
Ба	24	25	1	0.37
Ба	28	32	4	0.34
Ба	35	36	1	0.51
Ба	39	40	1	0.32
Ба	71	72	1	0.35
AAD-143	5	19	14	5.44
Үүнд	12	15	3 ⁽²⁾	18.74
AAD-144	13	49	36	1.25
AAD-145	41	43	2	2.71
Ба	70	72	2	0.74
AAD-146	6	7	1	1.11
Ба	15	32	17	16.65
Үүнд	22	30	8	33.52
Үүнд	22	25	3 ⁽²⁾	65.00
Үүнд	27	30	3 ⁽²⁾	21.12
AAD-148	5	28	23	1.15
AAD-149	26	42	16	1.34
AAD-151	21	33	12	0.53
Ба	38	58	20	0.41
AAD-152	14	26	12	0.56
AAD-153	23	26	3	0.48
AAD-154	37	38	1	0.37

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
2. Бүх интервалд, дээжүүдэд >10 г/т алтны агуулга (1-1.5 метр) тодорхойлогдсон. Үүнд 11.21-ээс 89.26 г/т алтны агуулга бүхий дээжүүд багтаж байна.
3. Цооногийн төгсгөл

Хүснэгт 2: Хар Морийн Дэл (Хойд) талбайн 2021 оны 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох үр дүнгүүд (Бүх интервалууд дунджаар 0.30 г/т алтнаас өндөр агуулгатай)

Цооног	м-ээс	м хүртэл	интервал ⁽¹⁾	г/т алт
AAD-92X	53	85	32	0.51
Ба	96	98	2	0.50
Ба	108	120	12	0.50
Ба	132	150 ⁽³⁾	18	0.72
AAD-156	41	50	9	0.76
AAD-157	7	24	17	0.40
Ба	39	40 ⁽³⁾	1	0.65
AAD-158	16	26	10	0.76
AAD-159	7	9	2	0.32
AAD-160	15	16	1	0.59
Ба	20	24	4	0.36
Ба	32	40	8	0.99
AAD-161	8	10	2	0.60
Ба	36	40 ⁽³⁾	4	0.45
AAD-162	11	21	10	0.69
Ба	25	27	2	0.72
AAD-163	21	24	3	0.53
Ба	40	48	8	0.93
AAD-164	32	41	9	0.48
AAD-165	20	21	1	0.33
Ба	29	30	1	0.46
AAD-166	56	70	14	1.10
AAD-167	13	15	2	0.48

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
2. Бүх интервалд, дээжүүдэд >10 г/т алтны агуулга (1-1.5 метр) тодорхойлогдсон. Үүнд 11.21-ээс 89.26 г/т алтны агуулга бүхий дээжүүд багтаж байна.
3. Цооногийн төгсгөл

Хар Морийн Дэл талбайн исэлдсэн хүдэр бүхий бүсийн өмнө зүгт 350 метр талбайд 200 метрийн турш үргэлжлэх өндөр алтны агуулга бүхий бүс багтаж байгаа нь энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрийн зорилтот бүс байв. Исэлдлийн гүн нь тухайн хэсэгтээ 100 метр гаруй байсан нь структурын дагуу гүний элэгдэлтэй холбоотой. Энэхүү өндөр агуулга бүхий төв бүсэд гол эрдэсжсэн биет нь газрын гадаргаас 1 метрээс эхлэн, 10-40 метрийн зузаан байна. Хөндлөн огтлол 1, 2-р зурагт үзүүлж, тайлснаар Хар Морийн Дэлийн алтны эрдэсжилтийн тренд нь хойд зүг рүү сунаж байрласан. Урьд нь танилцуулж байсан AAD-57 цооногийг маш өндөр агуулга бүхий бүсэд хойд зүгт 200 метрийн босоо гүнд өрөмдсөн бөгөөд 4 г/т алтны агуулгаас өндөр 2 метрийн хэд хэдэн интервал илэрсэн. Эдгээр үр дүнгүүдээс харахад газрын дөт гүнд илэрсэн алтны эрдэсжилт гүндээ үргэлжилж байх боломжтой. Мөн энэхүү доош сунасан эрдэсжилт нь өнөөг хүртэл судалгаа хийгдээгүй Хар Морийн Дэл талбайн хойд хэсэгт гүндээ үргэлжилж байх боломжтой.

Хар Морийн Дэл талбайн өмнөд бүсэд хоёр гүн цооног өрөмдсөн. AAD-68 цооногийн өргөтгөл нь хүчтэй тектоник брекч, өндөр нягтралтай кальцит штокверк судал болон брекч бүхий кварц турмалин метасоматжсан бүсүүдээр тодорхойлогддог томоохон хагарлын структурыг огтолсон. Алтны агуулга бага эсвэл тодорхой хэсэгт аномаль байгаа ч гүндээ зэсийн агуулга өсч, цооног 98 хувийн аномаль (700 ppm-ээс дээш) зэсийн агуулгатай төгссөн. AAD-134 цооногийг босоо гүнд 210 метр өрөмдсөн бөгөөд цооногийн турш филлийн хувирал бүхий галт уулын аномаль алт ба зэсийн бүсийг огтолсон нь хувирал болон эрдэсжсэн бүс үргэлжилж байгаа тайллыг дэмжиж байна.

Хар Морийн Дэлийн хойд хэсэгт 12 шинэ цооног өрөмдсөн нь багаас дунд исэлдэл бүхий хүдрийн алтны агуулгатай интервалуудыг огтолсон. Энэ нь салаалсан эсвэл зэрэгцээ орших алтны бүсүүд байх боломжтойг харууллаа (AAD-166). Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хойд бүсэд өрөмдсөн гурван гүний цооногийн нэгийг (AAD-92) гүндээ 150 метрээр тэлсэн. Үр дүнд нь алт агуулсан, үргэлжлэн эрчимтэй хувирч буй филийн хувирсан галт уулын нэгжийг агуулсан ширхэгжсэн кварц-гематитийн судлууд бүхий хэд хэдэн бүсийг амжилттай огтолсноор цооног 1 г/т алтны агуулга бүхий материалаар төгсөв. AAD-92 цооног нь 0.5 г/т алтны агуулга бүхий 130 метр интервал агуулсан AAD-61 цооног (2021 оны 4 сарын 22-нд танилцуулсан)-той зэргэлдээ оршдог. Эдгээр үр дүнгүүд нь Хар Морийн Дэлийн хойд бүсийн төв хэсэгт гүндээ маш хүчтэй, судлагдаагүй зорилтот бүс байгааг харууллаа (Хөндлөн зүсэлт 3-р зураг). Урьд нь танилцуулж байсан Хар Морийн Дэл (хойд)-ийн үр дүнгүүдэд ойролцоогоор босоо гүнд 100 метрт 16.2 г/т алтны агуулга бүхий 1 метр (AAD-51) зэрэг өндөр агуулгатай интервал багтаж байсан нь өндөр агуулга бүхий алтны эрдэсжилт гүндээ үргэлжлэх боломжтойг баталж байна.

Компанийн сүүлийн үеийн геологийн загварчлалаар энэхүү сонирхолтой нээлтийн эрдсийн нөөцийг үнэлэх хэд хэдэн зорилтот хайгуулын талбайг тодорхойлсон. Хар Морь болон өргөн цар хүрээ бүхий талбайд хийгдэх томоохон хэмжээний өрөмдлөгийн хөтөлбөрийг тодорхойлох зорилгоор мэдээллийг нэгтгэх, тайллын ажлууд үргэлжилж байна.

Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцийн хос плазмт спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг. Шигшүүрийн шинжилгээний агуулгыг мэдээлсэн.

Ирээдүйн төлөвлөгөө

Улаан талбайн өндөр агуулга бүхий алтны шинэ нээлтийн үргэлжлэл, тэлэх боломжийг судлах өрөмдлөгийн хөтөлбөрийг (2021 оны 10 сарын 20 хэвлэлийн мэдээ) эхлүүлсэн бөгөөд 4-р улиралд Хар Морь талбайн өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлнэ. Хар Морь дахь өрөмдлөгийн хөтөлбөр нь Баян Хөндий болон Хар Морь (өмнөд)-ийн хооронд орших 2.4 км структур, хойд хэсэг дэх бүсийн тэлэлтийг шалгах зорилготой. Цооногуудыг дундаж гүнд (200-300 метр) өрөмдөхөөр төлөвлөсөн.

Алт агуулсан исэлдсэн хүдэр бүхий бүсүүдийн Хөндий-Улаан хувирлын мөр дэх элэгдлийн түвшин, гидрологи болон уур амьсгалын нөхцөл байдал нь гүн исэлдэн, супергенээр баяжсан алтны эрдэсжилтэд эерэгээр нөлөөлснийг харуулж байна. Эдгээр исэлдсэн бүсүүд нь газрын гадарга дээр ховор илэрдэг бөгөөд эдгээр нь үндсэн биетийг бүрхсэн шүүрлийн байршилтай холбоотой байдаг нь зарим тохиолдолд нэг метрээс багагүй. Түүнээс гадна, тандалтын өрөмдлөгийг ихэвчлэн босоо гүнд 50 метрээр төлөвлөсөн нь хамгийн өндөр агуулгатай алтны исэлдсэн хүдрийн гүнийг хамарна. Хар Морийн Дэл өрөмдлөгийн үр дүн нь газрын дөт гүнд, томоохон хэмжээний исэлдсэн хүдэр бүхий алтны бүс байгааг илтгэх бөгөөд 2022 онд тусгай зөвшөөрлийн талбайд хэрэгжүүлэх өрөмдлөгийн хөтөлбөрийн зорилтот шинэ талбайг тодорхойлох боломжтой боллоо. Эрдэнэ Ресурс нь Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн талбайд өндөр нягтралтай геохимийн дээжийн судалгаа, газрын дөт гүнд шнек өрөмдлөг хийн, гүний чулуулгийн болон далд ургацыг судлахаар төлөвлөж байна. Түүнээс гадна Компани нь гадаргын төмрийн ислийн тэмдэглэгээг онилон өндөр нарийвчлалтай спектрийн алсын зайны тандалт судалгаа хийж байна.

Хар Морь талбайн тухай

Эрдэнэ Ресурс нь 2021 оны эхээр Баян Хөндий ордоос хойд зүгт 2.4 км-т өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэснээр Хар Морийн Дэл бүсийг илрүүлсэн. Энэхүү өрөмдлөгөөр (AAD-58) цооногийн 10 метрээс 27.1 г/т алтны агуулга бүхий 8 метр агуулсан 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон. Хар Морийн Дэл нээлтийг Баян Хөндий алтны ордыг нээн илрүүлснээс хойш Хөндий Алтны Дүүрэгт илрүүлсэн хамгийн чухал алтны эрдэсжсэн бүс хэмээн тодорхойлсон. Компани нь өнөөг хүртэл Хар Морь талбайд 4.6 км (зүүн-баруун) 2.6 км (хойд-урд) бүсийг хамарч, 14,681 метрийн 128 цооног өрөмдсөн. Цооногуудын босоо гүн нь 21-318 метрийн хооронд байсан бөгөөд дунджаар 87 метр байна.

Хар Морийн Дэл бүс нь голлох эрдэсжүүлэгч шингэнийг дамжуулагч хэмээн үзэж, зүүн хойд трендийн гүнд байрлах хувирлын хагарлыг огтолсон хойд-өмнөд трендийн шугаман структурын коридортой холбоотой. Алтны эрдэсжилт нь кварц, кварц-гематит судлууд болон штокверк бүсүүдээр огтлолцсон хүчтэй хувирсан туф болон галт уулын чулуулагт оршиж байна. Хар Морийн Дэлд хийсэн өрөмдлөгөөр газрын гадаргаас эхлэн 1 метрийн 89.3 г/т хүртэл супергенээр баяжуулсан алтны агуулга бүхий исэлдсэн хүдрийн бүс байгааг баталсан. Өндөр агуулга бүхий

исэлдсэн хүдэр нь хойд-өмнөд судлын дагуу үргэлжилж байна. Эрдэсжилт болон исэлдлийн хязгаар нь судлын дагуу болон гүндээ шалгагдаагүй хэвээр байна.

Хөндий-Улаан эрдэсжсэн систем

Улаан тусгай зөвшөөрлийн талбай болон Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий-Улаан гидротермаль хувирлын бүсийг агуулан, 4,000 гаруй га талбайг хамран оршдог бөгөөд хувирлын бүс нь Улаанаас зүүн хойш чиглэн 10 км үргэлжилдэг. Энэхүү хувирлын тренд нь Баян Хөндий алтны ордыг агуулагч цагаан гялтгануур, серицитийн гадна бүс болон серицитийн хувирлын захаар хүрээлүүлсэн хүчтэй хоёрдогч цахиурын төв бүсийг агуулдаг. Энэхүү зүүн өмнөд трендийн дагуу хувирсан бүсэд Улаан, Баян Хөндий болон бусад эрдэсжсэн хэтийн төлөв бүхий талбай (Хар Морь ба Алтан Сум талбай) багтаж байгаа нь зүүн өмнөд трендийн хагарлын дагуу бүс нутгийн структурын тэлэлтийн тэгш бус байдал ба томоохон галт уул - плутоник төвтэй холбогддог. Хөндий-Улаан талбай дахь хэтийн төлөв бүхий болон зэргэлдээ орших бүсүүдийн эрдэсжилт, хувирлууд нь томоохон структурын дагуу давхцаж эсвэл сунаж эрдэсжсэн нуман шилжилт бүхий баялаг магмын арлын нуман хувиралтай уялддаг.

Хөндий-Улаан гидротермаль хувирал нь 10 км гаруй талбайг хамран, Эрдэнэ Ресурсийн Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай болон Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд төвлөрсөн аргил, фил болон цахиурын хувирлын тэмдэглэгээгээр тодорхойлогддог. Хөндий-Улаан хувирлын мөрөөр хэд хэдэн алтны илрэлүүд болон геохимийн ба/эсвэл геофизикийн аномаль илэрсэн бөгөөд одоогоор хязгаарлагдмал судалгаа хийгдсэн.

Өнөөдрийг хүртэл хийсэн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүнгээс харахад Хөндий-Улаан хувирлын систем болон алтны илрэлүүд илэрсэн энэхүү том алт агуулагч гидротермаль систем нь бүрэн судлагдаагүй хэвээр байна. Өнөөг хүртэл тогтоогдсон алтны эрдэсжилт нь Хөндий-Улаан гидротермаль хувирлын системийн хязгаарын дагуу тэлсэн цагаан гялтгануур ба цахиураар хувирсан туфын үед байрладаг. Кварцын судал, шаврын хувирлын бүтцээс харахад Хөндий-Улаан системд томоохон эпитеpmаль хэв шинжийн алтны эрдэсжилтийг агуулж, туфын литологи нь алтны эрдэсжилтийг бүрдүүлэх таатай орчинг бий болгож ээ. Одоогоор Хөндий-Улаан талбайд хэд хэдэн геологи, геохими болон геофизикийн зорилтуудыг шалгах хайгуулын төлөвлөгөөг боловсруулж байна.

Хөндий Алтны Дүүргийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардаг Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл ("Төсөл") хэмээн нэрлэдэг. Компани нь

түүнээс гадна Хөндий Алтны Дүүргийн зүүн зүгт 30 км-т өөрийн 100% эзэмшлийн Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд томоохон Зуун Мод молибден-зэсийн орд болон хэд хэдэн зэс ба молибденийн порфирийн хэтийн төлөв бүхий бүсүүдийг хөгжүүлж байна.

Баян Хөндийд 2.19 г/т дундаж алтны агуулга бүхий 585,100 унц баттай болон бодитой геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², 2.18 г/т алтны агуулга бүхий 35,900 унц боломжит нөөц (“Inferred Resources”)³ тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2023 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуулын 2, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг

1 Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2021 оны 8 сарын 16-нд танилцуулсан 2021 оны 2-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангийн хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

2 Баттай & Бодитой геологийн нөөц: 2.39 г/т алтны агуулга бүхий 232,700 унц баттай, 2.08 г/т алтны агуулга бүхий 352,400 унц бодитой нөөц

3 Батлагдсан & Магадалсан: 4.4. г/т алтны агуулга бүхий 165,000 унц батлагдсан, 3.4 г/т алтны агуулга бүхий 256,000 унц магадалсан үйлдвэрлэлийн нөөц; Үйлдвэрлэлийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөндий Алтны Төсөл NI 43-101 Техникийн Тайлан, Tetra Tech 2019 оны 12 сарын 4-нд SEDAR болон компанийн вебсайт дээрх мэдээлэлтэй танилцана уу.

Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Улаан талбайн өрөмдлөгийн цооногуудыг 85 градусын уналаар өрөмдсөн ба алт агуулсан судлын баруун-хойд баруун трендийн дагуу баруун урд уналын дагуу чиглэсэн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх

боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>


DARK HORSE DRILLING CONFIRMS OXIDE GOLD AT SURFACE

Khundii – Ulaan Licenses, Bayan Khundii Deposit and Prospect Location Map

Khundii – Ulaan Active Discoveries and Prospects





Khundii – Ulaan Hydrothermal Alteration Footprint



GREATER DARK HORSE EXPLORATION PLAN MAP

Dark Horse Mane Zone Inset




DARK HORSE MANE - SECTION 1

North-South Trending Long Sections


Dark Horse Mane- SECTION 1 LOOKING WEST

Gold Grades and Copper Anomalism with 3D Magnetics



Dark Horse Mane- SECTION 1 LOOKING WEST

Indicator Element Modelling and IP Chargeability + IP Metal Factor*




* (CHG/RES)x100

DARK HORSE MANE (SOUTH) - SECTION 2

High-Grade Oxide Gold Q4-2021 Highlights

DARK HORSE MANE (SOUTH)- SECTION LOOKING SOUTHWEST

Interpolated Gold Grades and Mineralization Trends



AAAD-146: 22 to 30m Au g/t


	89.3
	43.7
	62.1
	6.4
	3.5
	16.7
	18.6
	28.0

DARK HORSE MANE (NORTH)- SECTION 3

Q4-2021 Highlights- Increasing Width and Open at Depth

Dark Horse Mane (North)- SECTION LOOKING NORTH

Interpolated Gold Grades and Mineralization Trends with Downhole Gold Assay



DARK HORSE MANE CORE PHOTOS

Host rocks, alteration and veining styles at depth, Dark Horse south

AAD-134: (200-207m) Anomalous Au(>0.1g/t) and Cu in a brecciated, phyllic altered volcanic, white mica & calcite matrix cut by quartz-pyrite veins



AAD-68x: (384-390m) High density calcite stockwork veining and breccia zone; increasing Cu values with depth, hole terminating in >700ppm copper



AAD-68x: (268-275m) Quartz tourmaline hydrothermal alteration of volcanic, selective white mica alteration, locally vuggy with , elevated Au, Cu.



AAD-102: (60 to 67m) Magmatic hydrothermal breccia of quartz monzonite/dacite porphyry; strong silica and magnetite alteration with moderate phyllic. Locally elevated in both Au, Cu.



AAD-102-1



AAD-102-2

AAD-102 (62 and 72m depth): crackle and shingle breccias and calcite-dickite breccia infill. See close up images 1 and 2.